


12 Essences for Your Life

## Гурван тэмдэг буюу Бясалгалын амгалан ба Бүгд зовдогийн тухай сургаал

~ Үзэл бодлоо өөрчилбөл дэлхий өөрчлөгдөнө ~



12сарын дугаартаа “Бүх зүйлс тогтворгүй”, 1 сарын дугаарт “Бүх зүйлс холбоотой” байдгийн тухай өгүүлсэн бол энэ удаа Гурван тэмдэгийн сүүлийн сургаал болох “Бясалгалын амгалан”-гийн тухай танилцуулья.

Мөн энэ гурван сургаал дээр бас “Бүгд зовдог”-ийн тухай сургаал байдаг тул үүнийг бас дөрвөн сургаал гэж ч нэрлэдэг юм.

Бясалгалын амгалан гэдэг бол ямар ч төөрөгдөлгүй, сэтгэлийн тайван байдлыг хэлдэг. Гурван сургаалын “Бүх зүйлс

тогтворгүй”, “Бүх зүйлс холбоотой” гэдэг сургаалыг сайвтар эзэмшиж чадвал энэхүү гурав дахь сургаалын байдалд хүрч чадна гэсэн үг билээ. Эсрэгээр “Бүгд зовдог” гэдэг сургаал нь бүхий зүйлс нь зовлон байдаг гэсэн утгатай юм.


Жишээлбэл, бид хичнээн үүрд залуугаараа байхсан гэж хүссэн ч цаг хугацааг зогсоож чадахгүй. Хэн ч өтөлж хөгширдөг. Өөрийгөө ойрын үед мартамхай болчихож, нүүр арьс өнгөлөг биш боллоо, хөл гар хөшдөг боллоо гэж бодогдох үе бий биз дээ? Үүнээсээ болоод санаа алдаж орхидог үе ч бий байх. Гэвч хөгшрөх тусам хүн илүү ухаалаг, эелдэг болдог байна. Залуу үедээ анзаардаггүй байсан зүйлийг анзаарч хардаг болдог. Ийнхүү хүн байнгын өөрчлөлтийн дунд амьдардаг тул өөрөө ч өөрчлөгдөн хөгждөг байна. Бид бүх зүйлс байнга өөрчлөгдөж, хоорондоо уялдаа холбоотой байдаг гэдгийг ухаарвал өдий хүртэл зөвхөн өөрийгөө л боддог байсан бол бүх юманд талархалын сэтгэлээр ханддаг болно.

Үүнийг үзэл бодлоо солино гэж хэлж болно. Үзэл бодлоо өөрчилж чадвал хэвшмэл үзэл санаанаасаа салж урагшаа хөгжих болно. Амьдрал ч илүү их сонирхолтой болно.

Дээрхи гурван сургаалыг хэрхэн эзэмших талаар дараа дугаартаа танилцуулья.

## Үндсэн буддизм

## Special Topics



Энэ удаа “Үндсэн буддизм” гэдэг үлгэрийн ном нь англи хэл дээр орчуулагдан Хойд Америкийн Олон Улсын Төвөөс хэвлэгдэн гарлаа. Орчуулгыг Хойд Америкийн лидер болох америк хүн орчуулж японы Олон Улсын Төв нь редакторлосон юм. Олон хүнд хэрэг болоосой гэж хүсэн найдаж байна.

Гарчиг: Basic Buddhism Through Comics (by Mitsutoshi Furuya)  
Хэвлэлийн газар: Rissho Kosei-kai International of North America  
Худалдан авах арга ба үнэ:

Нутаг газар	Худалдан авах арга	Үнэ
Ази тивийн хаяг	Косэй Хэвлэлийн газар: ( <a href="mailto:kspub@kosei-shuppan.co.jp">kspub@kosei-shuppan.co.jp</a> ) Оказаки уруу холбоо бариарай. *Хувиараа авах тохиолдолд кредит картаар төлнө.	950йен (татвар орсон) + шуудангийн төлбөр
Дээрхээс бусад хаяг	Зсараас ойрын номын дэлгүүрээс захиалгаар авч болно.	US\$9.95 + TAX

# Тэвчээрийн хүч

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч  
Нивано Ничикоу

## Уураар буцаахгүй

Шагжамүниг нэгэн удаа нэг залуу барамон шавь нь буруутган муулж,элдвээр доромжилсон билээ.Гэвч Шагжамүни түүний нурших олон эвгүй үгийг дуугаа сонсоны дараа ийнхүү өгүүлжээ:

“Хэрэв танай гэрт хүлээн авалт зохиогдож,ширээн дээр бэлдэн тавьсан хоолыг хэн ч идээгүй байвал та яах вэ?”

Үүнд залуу:”Тэгвэл тэр зоог нь бүгд минийх болно” гэж хариулжээ.Шагжамүни нь:”Чиний надад хэлсэн хортой бүх үгнүүдийг чинь би хүлээн аваагүй ээ.Тэгвэл тэдгээр уур уцаар нь хэний өмч болж таарах вэ?” гэж зөөлөн асуусан гэнэ.

Энэ бол Буддын нэгэн цуу яриа боловч бидний амьдралд үүнтэй адил тохиолдол элбэг гардаг.

Хүнд аашлуулан загинуулах,эсвэл өөрөө хүнд уурлан хилэгнэх тохиол олонтаа гардаг билээ.Өнөөгийн нийгэм нь стрессээр дүүрсэн байгаа бөгөөд хүн уур хилэндээ автагдаж,эрх чөлөөгүй,ямагт тэсч ядаж байх нөхцөлд байдаг.

Ийм нөхцөл байдалд дээрх өгүүлсэн богино жишээ нь бидэнд ихийг зааж байгаа билээ.

Үүнд юуны өмнө Шагжамүни нь ууранд автагдсан залуутай өрсөлдөн байлдаагүй явдал чухал юм.Мөн их уур хилэнгээр загинуулсан ч түүнийг хүлээн авч эргүүлэн уурлаагүй явдал билээ.

Нэгэн хүн уур гэдэг бол тэнэгэлзэлийн илрэл бөгөөд хүнд учрагдах байгалийн нэгэн үзэгдэл мөн гэж тайлбарласан байдаг.Өөрт гарч ирэх уураас илүү хүний ууранд эргүүлэн уурлаж,улмаар үзэн ядах,муу бодох сэтгэл төрдөг байна.Уур хилэнд автагдсан залууд Шагжамүни нь тэсвэрийн чадлыг үзүүлж,зөөлөн тайван хариулж чадсан билээ.

Сүүлд нь Шагжамүни ингэж өгүүлсэн байна:

“Би бол ууранд уураар буцаан хариулахгүй.Харин эсрэгээр сэтгэлээ барихыг хичээдэг.Энэ бол миний сэтгэл зүйн хөгжил юм”.

## Жинхэнэ Үнэнийг мэдэрснээр

Уур хилэн бол хичнээн үүнийг зөвтгөх шалтгаан байсан ч томоор авч үзвэл дайн үүсгэж,бүхий юмыг устгаж орхидог хүчинтэй.Хувь хүний хувьд бол уурнаасаа болж анд нөхөдтэйгээ хагацаж,улмаар ганцаарын зовлонг эдлэх болно.Энэ бол Буддын сургаалд байдаг арван ертөнцийн доторх тамын ертөнц юм.



Тийм учраас Шагжамүнитэй адил өдөр тутмынхаа амьдралдаа уур хилэнгээ хэрхэн давж,удирдах нь их чухал билээ.

Манай сударт ч “бүхий хүмүүст тэвчээрийн сэтгэл олгомүй” гэсэн сургаал байдаг билээ.Уураа барих эхний алхам бол юуны өмнө чимээгүй болох явдал билээ.Ингэснээр яваандаа шал дэмий юманд уурлаж байсанаа ойлгож тайвширдаг тохиол их байдаг.

Мөн хүнд ямагт талархаж байх,элдэг зөөлөн харьцаж байх нь уур уцаарыг намдааж,хүнийг тайван болгодог байна.Өөрөөр хэлбэл,зөвхөн тэвчээд байх биш харин өөрөөсөө түрүүлж хүнийг байгаагаар нь хүлээн авснаар тэвчиж байгаа гэсэн сэтгэгдэл өөрийн эрхгүй алга болдог байна.

Ийм үед Жинхэнэ Үнэнийг мэдрэх явдал чухал юм.

Энэ бол бүгд нэгэн Амийн эх үүсвэртэй бөгөөд учир шалтгааны харилцааны ертөнцөд амьдардаг гэдэг үнэнийг ямагт санах явдал юм.Тэгснээр өөрт ч гэсэн ямар нэгэн алдаа дутагдал байсан болов уу гэж бодох сэтгэл төрж,аливаа зүйлд тэсвэртэй,тайван ханддаг болно.

Сударт бас Жинхэнэ Үнэнийг мэдэрч,оюун ухааны нүдээ нээвэл уур уцаарын үндэс нь арилж алга болно гэсэн байдаг.

Тэвчээрийн хүч чадал нь оюун ухааны үйл ажиллагаанаас шалтгаална.

Энэ нь мунхаг тэнэгийг арилгаж,бусдыг бодох нигүүлсэхүйн сэтгэлийг төрүүлж,энх тайван ертөнцийг бүрдүүлдэг байна.

“Косэй” 2010 оны 2 дугаар сарын дугаараас

# Нэгэн бие сэтгэл ---Бидний одоо ба ирээдүй

Жён Майкл Кёожи Шюү  
Нью-Йорк нийгэмлэг, Чикаго салбар

Энэхүү дурсамж яриа нь 2009 оны 8 сарын 1-нд “Хойд Америкийн нийгэмлэгийн 50 жилийн ойн баяр”-т зохиогдсон бөгөөд 2 хувааж танилцуулах болно.

Энэхүү илтгэлийг бэлдэж байх үед би өөрийнхөө өдий хүртэлх амьдрал, хийсэн зүйл, сонголт, тэмцлийн тухай бодож олон цаг зарцуулсан. Хэцүү байсан боловч энэхүү илтгэл нь миний өсөлт хөгжлийг харуулж өгсөн Буддагийн нигүүлсэхүй юм. Мөн хүнд хууртагдан хаягдсан үеийн дурсамж ба хүмүүс намайг хүлээн авч зөвшөөрсөн үеийн дурсамжуудыг дахин сэргээн бодох завшааныг Будда надад олгосон билээ. Миний сэтгэл эдгээр өнгөрсөн үйл явдлуудаас их нөлөө авдаг байсан гэдгийг би саяхан ойлгосон. Өдий хүртэл би хүнтэй харьцахдаа хүнтэй нэгэн бие сэтгэлээр биш хөндий зайтай харьцдаг байсан тул үүгээр олон хүний сэтгэлийг шархлуулсан боловч уу гэж бодогдсон юм.

Би бага залуу үедээ өөрийнхөө гэр бүл, сургууль, шашинаас болж ихэд зовлон үзэж, бүгд намайг урваж хаясаны тухай өмнө нь ярьсан билээ. Мөн том болоод РКК-тай учирч, сэтгэлийн шинэ гэр бүлтэй болж, намайг шашинд найрсгаар хөтлөн оруулсан эцэг болох Сато саны тухай ч ярьсан билээ.

Өнөөдөр энд цугларсан ихэнх хүмүүс РКК-ийн гишүүд билээ. Бид бүхэн тус тусын амьдралыг туулан ирж энэхүү сэтгэлийн шинэ нутагтай болсон юм. Энд биднийг хэн ч гэсэн хүлээн авч урина. Ийнхүү РКК-ийн гишүүд бидний санга бол маш хүчин төгөлдөртэй зүйл юм. Үүнд биднийг анх ийшээ хөтлөн дагуулж, сургаалыг зааж өгсөн багш нарын маань ач гавьяа их билээ.

Одоо бид эргээд бусдад хэрхэн аз жаргалтай болох талаар зааж, сангадаа урьж оруулах ээлж ирсэн. “Тус тусын бие боловч нэгэн сэтгэл”-тэй болохын тулд бид одоо Нэгэн Их Амийн тухай сайвтар эргэцүүлэн бодож, зөвхөн үгээр биш үйлээр харуулан хөдлөх хэрэгтэй. Бид хүмүүсийг хоза цуглаандаа урьж дуудаж байна уу? Бид баяртайгаар даяан хийдэг үү? Өөрсдийнхөө сургаалын багш нараа хайрлан хүндэлдэг үү? Ямар

ч төрлийн үзэгдэлд сэтгэлээ нээн хүлээн авдаг уу? Өөр өөр соёлын ханыг даван туулж чаддаг уу?

“Өөр өөр, олон янзын байдал үзэгдлүүд хамт амьдрал туулахад хэцүү зүйл боловч огт байхгүй бол аюултай болно” гэж Вильям Срон Кофийн мэргэн багш хэлсэн билээ. Бид илүү их олон замтай амьдралыг сонгох эрхтэй. РКК-г Америкт хөгжүүлж гэвэл бид ийнхүү олон талын зам аргыг хэрэглэж, Нивано Никкё багш шиг сургаалыг олон хүнд танилцуулан дэлгэрүүлэх хэрэгтэй.

Хүнийг уриалан дуудаж, сангагийн хүрээг тэнийлцгээе. Америк дахь РКК-ийн гишүүд бид юунаас ч айж зоволтгүй гэр бүл, сургууль, ажил дээрээ Цагаан Лянхуа Цэцгийн сургаалын тухай ярьж, заах хэрэгтэй.

Бидний нийгэмлэг шинэ хүмүүсийг эелдэгээр хүлээн авдаг нэгэн сэтгэл санааны газар болоосой гэж хүсэж байна.

Америкийн гишүүд бид япон гишүүдээсээ суралцаж, сургаалынхаа тухай ний нуугүй ярьж чаддаг болох шаардлагатай. РКК-ийн сургаалын ач буянаар бид хэрхэн аврагдсанаа бусдад танилцуулах хэрэгтэй.

Хүнийг шашиндаа хөтлөн оруулах, даяан үйлдэх гэсэн үйл ажиллагаа бол бодисадвагийн үйлийн дотор хамгийн их гайхамшигтай сайхан үйл юм. Хэн нэгнийг шинээр дагуулан ирснээр тэр хүнийг хүлээн авч, сургаалын замд хөтлөн оруулж өгөх “эцэг, эх” бол маш хүндтэй бөгөөд хариуцлагатай даалгавар дааж явах болно. Багш шавийн харилцаанд орсноор бие биенээ улам хөгжүүлж, ойлголцох завшаантай болж байгаа юм. Бие биенийгээ хөгжүүлэхээс гадна бас сургаалаа өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэгжүүлж явахаа ч суралцана. Ийнхүү багш шавийн харилцаан дээр бас хозагийн хичээл нэмэгдэж энэ бүхэн нь РКК-г маш өвөрмөц



болгодог онцлог чанар юм.

Бид бүхэн бол өөр өөр биетэй боловч нэгэн зүрх сэтгэлтэй болохыг зорьдог.Тийм учраас манай нийгэмлэг америкийн бусад буддын нийгэмлэгтэй адил зөвхөн хувь хүний гэгээрлийг зорьдоггүй.Бид бол гар гараа барилцаж,нэгэн зам туулж байгаа билээ.

Мөн америкийн РКК нь үүнээс хойш олон төрлийн өвөрмөц чанартай хүнийг хүлээн авч чаддаг сангаг хүмүүжүүлэн хөгжүүлэх шаардлагатай.Энэ нь манай нийгэмлэг бол хүнийг яс үндэс,гарал төрөл,арьсны өнгө,соёл иргэншил,эдийн засгийн байдал ба хүйсээр нь ялгадаггүй, гомо гэх мэт төрлийн хүнийг ч гадуурхалгүй хүлээн авдаг гэдгийг ертөнцөд үзүүлэн мэдэгдэх хэрэгтэй.

Манай сангагийн нэгэн зүрх сэтгэлгээ бидний өвөг дээдэст ч хамаарагдах ёстой.Өвөг дээдсээ хүндлэн дээдлэх нь гэр бүлийг бэхжүүлж,найрсаг болгодог.Бид РКК-ийн төлөө шамдан хичээвэл энэ нь хэзээ нэгэн цагт заавал ямар нэгэн үр дүнд хүргэнэ.

РКК-н гишүүд бид хүчээ нэгтгэж биднийг хааж буй ханыг нураан хаяснаар нигүүлсэхүйн хүрээгээ улам тэнийлгэж чадна.

Эцэст нь хэлэхэд бид жинхэнэ гэгээрэлд хүрэхийн тулд юуны өмнө хүмүүстэй баяртайгаар,найрсаг харьцах хэрэгтэй юм.


Хүмүүст энэхүү гайхамшигтай сургаалаа зааж өгье.Бид бие сэтгэлээрээ ямагт бодисадвагийн үйл хийж байвал хэзээ нэгэн цагт заавал Буддын гэгээрэлд хүрч чадна.Энэ бол бид өдөр тутам сургаалын замаараа явж,сургаалаа амьдралд хэрэгжүүлсний үр дүн болно.

Ингээд эцэст нь сургаалын үгнээс ишлэл татъя:

“Та өөрөө өөрийгөө гэрэлтүүлэн яв,сургаалыг өөрийнхөө гэрэл гэгээ болго”.

Будда,Үүсгэн Байгуулагч,Ерөнхийлөгч болон та бүхэнд чин сэтгэлээсээ талархаж байна.

Дуусав



## Сансарын санаанд таарсан зохицол

Хүн бол үндсэндээ бүгд эрх тэгш гэдгийг дахин сануулья.Гэвч хүн хүйс,хүч чадал,зан ааш,авъяасаараа тус бүрдээ өөр өөр билээ.

Уг үндсэндээ бүгд эрх тэгш боловч яагаад иймэрхүү янзаар өөр өөр болдог вэ?Энэ бол “байх ёстой ялгаа” буюу “сансар хүнийг тийм онцлогтой байлгах хэрэгцээтэй” байгаа юм.

Нүдэнд бол нүдний,зүрхэнд бол зүрхний,гэдсэнд бол гэдэсний үйл ажиллагаа ба үүрэг байдаг.Эдгээрийг хооронд нь сольж болохгүй.Бүх эрхтэнгүүд зөвхөн өөрийн хийх ёстой үүрэгтэй билээ.Чухам тийм үйл ажиллагааны ачаар бидний бие махбоди бүтэж амь явдаг байна.Бүх эрхтэнгүүдийн тус тусын үйл ажиллагааны

ачаар л биений бүхий зохицол хадгалагддаг юм.

Үүнтэй адил хүн ч тус тусын ааш зан,хүч чадал,авъяасаараа ялгагдаж цугларснаараа нийгэм үүсч,амьдрал амт шимтэй болдог.Мөн өөр өөр зантай хүмүүс бие биендээ хэрэгцээтэй нөлөө өгч,улмаар тус тусдаа хөгждөг байна.Энэ бүгдийн уг үндсэнд сансарын санаа агуулагдаж байгаа юм.Шашны хэллэгээр хэлбэл,энэ бол Бурханы санаа буюу Мөнхийн Үндсэн Буддагийн хүсэлийн илрэл юм.

Үүсгэн Байгуулагчийн үг 14-15х.

### \*\*\* Column \*\*\*

Тэр өдөр Оклахома хот урьд өмнө нь үзээгүй айхтар хүйтэн цаг агаарт автагдсан билээ.Хасах 18 хэм.Би ч ийм хүйтнийг анх удаа үзсэн юм.Гэвч Оклахомагийн нийгэмлэгийн дождё дээр очиход тэс өөр ертөнц байв.Тэр өдөр тус нийгэмлэгийн хуучин дарга Ясүко нь шинээр дарга болох Крисийг угтан авах баярын үйл ажиллагаа болж байсан юм.Ясүко хатагтай анх Оклахомад 10 жилийн өмнө ирсэн билээ.Тэр үеэс л америкчүүдэд сургаалыг дамжуулахсан гэсэн бодолтой байсан.Гэвч бодит амьдрал дээр олон даваа байсан юм.Хэд хэдэн удаа сэтгэлээр унах тохиолдол ч гарсан.Тийм үед Крис элсэж ирсэн юм.Ясүко хатагтай Крисийг урдаа барьж гишүүдээ дэмжиж ирсэн билээ.Үүний ачаар гайхамшигтай америк ламыг хүмүүжүүлэн сургасан юм.1 сарын 10-нд болсон ёслолын үйл ажиллагаанд ирсэн бүх гишүүд үүнийг сайн мэдэж байсан.Бүх хүмүүсийн талархалын сэтгэл гадааны хүйтнийг мартуулж чадсан юм.Ийнхүү америк хүний удирдлагын дор явагдах Америк дахь буддын сургаалын үйл ажиллагааг дэмжицгээе.

(Kotaro Suzuki)

## Ришшё Косэйкайгийн тухайд

Ришшё Косэйкай бол 1938 онд Үүсгэн Байгуулагч Нивано Никкё ба Наганума Мёко санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Уг байгууллага нь “Лянхуа цэцэгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож,гэр орондоо шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр ба сургаалийг амьдрал ахуй, нийгэмдээ хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайвныг зорьж байгаа юм.



## SHAN-ZAI 2010он 2сар (Vol.53)

【Үүсгэн гаргагч】 Ришшё Косэйкай Олон улсын салбар Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail : shanzai@kosei-kai.or.jp  
Редатор:Огивара Туслах:Мизумо Ажилчид:Мацуока,Икебүчи,Имафүжи Prararan Seinarat,Кизүка, Kaoru Saito

※Энэхүү сэтгүүл нь япон,англи,хятад,солонгос хэл дээр гардаг бөгөөд зарим дугаарууд нь бусад хэл дээр бас гардаг юм. ※Санаа сэтгэгдэл байвал холбоо барина уу. ※Мөн хувийн зорилгоор ашиглах үед Олон улсын салбар луу холбоо барина уу s.

# Rissho Kosei-kai Overseas' Dharma Centers

# 2010

## Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

## Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,  
CA 92612, U.S.A.  
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432  
e-mail: info@buddhistcenter-rkina.org http://www.buddhistcenter-rkina.org

## Brunch under RKINA

### Rissho Kosei-kai of Tampa Bay

c/o Unitarian Universalists of Clearwater 2470 Nursery Rd.  
Clearwater, FL 33764, USA

## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633  
e-mail: info@mail.rkhawaii.org http://www.rkhawaii.org

### Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.  
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

### Rissho Kosei-kai Kona Branch

73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96750, U.S.A.  
Tel & Fax: 1-808-325-0015

## Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567  
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

### Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745  
e-mail: trina\_ozuna@juno.com

### Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

### Rissho Kosei-kai Buddhist Center of Denver

### Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

### Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569  
e-mail: rkksf@sbcglobal.net

### Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.  
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261  
e-mail: rkseattle@juno.com

### Rissho Kosei-kai of Sacramento

### Rissho Kosei-kai of San Jose

### Rissho Kosei-kai of Vancouver

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.  
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499  
e-mail: koseiny@aol.com

### Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.  
Tel & Fax: 1-847-394-0809  
e-mail: murakami3370@hotmail.com

## Rissho Kosei-kai of Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.  
Tel & Fax: 1-405-943-5030  
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

### Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

### Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St. Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.  
Tel: 1-541-810-8127

### Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

4340 E Kentucky Ave #345 Glendale CO 80234, U.S.A.  
Tel: 1-303-319-2765 Fax: 1-720-876-4534

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
CEP 04116-060, Brasil  
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304  
e-mail: hiromi\_mat@yahoo.com http://www.rkk.org.br

### Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
CEP 08730-000, Brasil  
Tel: 55-11-4724-8862

## Rissho Kosei-kai of Taipei

4F, No.10 Hengyang Road, Zhongzheng District, Taipei City 100  
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

### Rissho Kosei-kai of Taichung

No.19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,  
Taichung City 401  
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

### Rissho Kosei-kai of Jilong

## Rissho Kosei-kai of Tainan

No.45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701  
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

### Rissho Kosei-kai of Pingtung

No.4, Lane 60, Minquan Road, Pingtung City,  
Pingtung County 900  
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

## Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea  
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696  
e-mail: krkk1125@hotmail.com

### Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,  
Republic of Korea  
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

### Korean Rissho Kosei-kai of Masan

## Branches under the Headquarters

### Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,  
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic  
of China  
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

### Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39 Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,  
Ulaanbaatar, Mongolia  
Tel & Fax: 976-11-318667  
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

### Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar,  
Mongolia

**Rissho Kosei-kai of Sakhalin**

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk  
693000, the Russian Federation  
*Tel & Fax: 7-4242-43-78-56*

**Rissho Kosei-kai (Geneva)**

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland  
*Tel: 41-22-791-6261 Fax: 41-22-710-2053*  
*e-mail: rkkgva@wcc-coe.org*

**Rissho Kosei-kai of the UK****Rissho Kosei-kai of Venezia**

CASTELLO – 2229 30122 – VENEZIA VE ITALY  
*Tel: 0039-3282-60-4071*

**Rissho Kosei-kai of Paris**

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France  
*Tel: 0033-6131-48645/0033-1484-55750*

**Rissho Kosei-kai of Sydney****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224*  
*e-mail: ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibc-rk.org/*

**Rissho Kosei-kai of South Asia Division**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel: 81-3-5341-1017 Fax: 81-3-5341-1224*

**Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218*  
*e-mail: thairissho@csloxinfo.com*

**Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel: 880-31-2850238 Fax: 880-31-710572 (c/o Hotel Agrabad)*  
*e-mail: bimanrkkbimanrkk@yahoo.com*

**Rissho Kosei-kai of Dhaka**

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,  
Dhaka Cant.-1206, Bangladesh  
*Tel: 880-2-8316887*

**Rissho Kosei-kai of Mayani**

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Srilanka**

No. 18 Anura Mawatha, Off Anderson Road, Kalubovila, Dehiwala, Sri Lanka  
*Tel: 94-11-2763035 Fax: 94-11-4205632*  
*e-mail: rkksrilanka@visualnet.lk*

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Galle**

“Suwisal” Bataganwila, Imaduwa, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

**Branches under the South Asia Division****Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,  
New Delhi-110019, India  
*Tel: 91-11-2623-5060 Fax: 91-11-2685-5713*  
*e-mail: sakusena@hotmail.com*

**Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,  
KOLKATA 700094, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal  
*Tel: 977-1-552-9464 Fax: 977-1-553-9832*  
*e-mail: nrkk@wlink.com.np*

**Rissho Kosei-kai of Lumbini**

Shantiban, Lumbini, Nepal

**Affiliation****Friends of Rissho Kosei-kai in Shanghai**

114, Nanshi Si Road, Zenruzhen, Putuo-qu, Shanghai, China